



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/24

Жаргалтхаан сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.XVII жарны “Сүрээр дарагч” хэмээх гал морин жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж “Сумын алдарт уяач” цол хүртсэн Гичгэнэ багийн уяач Б.Цэрэнсамбуу, Чулуут багийн уяач П.Бямбадорж, З.Гантулга нарт хүндэтгэл үзүүлж гарын бэлэг олгосугай.

2.Уяачдын шагналд зориулж 180,000 (нэг зуун наян мянга) төгрөгийг зарцуулсугай.

3.Дээрх зардалд шаардагдах 180,000 (нэг зуун наян мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, Нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ